

**“Монгол улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаа, зээл олголтын үр дүн,
эргэн төлөлтийн байдал”
ҮАГ-ГАГ/2017/12-ГА-01**

2018-11-20

1. Зээл олгогдсон төслийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлсон эсэх

Монгол улсын Хөгжлийн банкнаас олгогдсон 2014-2016 онд Хэнтий аймагт 37 төсөл, арга хэмжээнд 4,0 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлт, хэрэгжилтийн байдал, үр дүнгийн хүрсэн талаарх мэдээллийг аудитын явцад шалгалаа.

Аудитаар тус 37 төслөөс 34 төсөл хэрэгжүүлэгчтэй холбогдож мэдээллийг нэгтгэсэн бөгөөд холбогдох салбарын яамнаас газар тариалангийн чиглэлээр олгогдсон 4 төсөл, сүү үйлдвэрлэлийн чиглэлээр олгогдсон 1 төсөл аудитад хамрагдсангүй.

“Хангай миллс” ХХК, “Энх ногоон тал” ХХК, “Биндэрьяа буудай” ХХК, “Эвийн хүч” ХХК, “Батширээт сүү” ХХК аудитад мэдээллээ ирүүлээгүй болно.

Хэнтий аймагт олгогдсон нийт төслүүдээс 198,3 сая төгрөгийн 10 төсөл нь хүнсний үйлдвэрлэл болон худалдааны чиглэлээр, 2961,0 сая төгрөгийн 6 төсөл нь газар тариалангийн чиглэлээр, 136,0 сая төгрөгийн 4 төсөл нь мал аж ахуйн чиглэлээр, 216,6 сая төгрөгийн 4 төсөл нь барилгын материалын чиглэлээр, 55,0 сая төгрөгийн 3 төсөл нь жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр, үлдсэн 448,4 сая төгрөгийн 10 төсөл нь бусад төрөл бүрийн үйлчилгээний чиглэлээр олгогдсон байна.

Уг төслүүдийн сонгон шалгаруулалтыг Хэнтий аймгийн Хөдөлмөрийн хэлтэс зохион байгуулж байгаад бүтцийн өөрчлөлтөөр татан буугдсан мөн тус төслийг хариуцсан ажилтан өөрчлөгдсөнөөс өнөөдөр зарим төслийн баримт бичгүүд алдагдсан болон өндөр үнийн дүн бүхий зээлийг орон нутгаар дамжуулалгүй салбарын яамнаас шууд олгосон зэргээс шалтгаалан төслийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг хэрхэн тодорхойлсныг тогтоох боломжгүй байлаа.

Хэнтий аймгийн Хөдөлмөрийн хэлтсээс сонгон шалгаруулсан “Нүүдэл” бэлэг дурсгалын төсөл, “Эко тоосго” төсөл, “Хос оёдол” оёдлын үйлдвэрлэл, “Гутал” төсөл, “Хэнтий гутал” өргөлтгөлийн төсөл, “Нутгийн талх” төсөл, “Мөнхийн шим” төсөл, “Нутгийн ааруул” төсөл, “Цагаан Онон” төсөл, “Зомсбэ” ХХК, “Түргэн хоол” төслүүдийн материал байхгүй байна.

2. Зээлийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх,

Хэнтий аймагт хэрэгжүүлэхээр олгогдсон 37 төсөл арга хэмжээнээс 34 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэгч нь төслийн хөрөнгийг тухайн төсөл, арга хэмжээнд зориулан ажлын байр бий болгох, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж худалдан авах, эргэлтийн хөрөнгөнд зарцуулах зэрэгт зориулсан байна.

Үүнээс 3 төсөл арга хэмжээ нь төслийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх нь тодорхойгүй, хэрэгжүүлэгчдийн хаяг тодорхойгүй эсвэл гадаадад гарсан зэргээс шалтгаалан аудитын хугацаанд төслийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг тогтоох боломжгүй байлаа.

Мөрөн суманд хэрэгжих 9,0 сая төгрөгийн ахуйн үйлчилгээний төв, Хэрлэн суманд хэрэгжих 38,0 сая төгрөгийн Эко тоосго, Бор-Өндөр суманд хэрэгжих 10 сая төгрөгийн “Шинэ сүү” төсөл хэрэгжээгүй байна.

1765,0 сая төгрөгийн 4 төслийн санхүүжилтийг салбарын яамнаас шууд олгосон тул зээлийн зориулалт болон хэрэгжилтийг тооцох боломжгүй байлаа.

Тус аймагт олгогдсон 2160,3 сая төгрөгийн 32 төсөл арга хэмжээний зээлийн эргэн төлөлт 56,4 хувь буюу 1218,7 сая төгрөгийн зээл эргэн төлөгдөж 43,6 хувь буюу 941,6 сая төгрөгийн зээл төлөгдөж дуусаагүй байна.

Тус Хөгжлийн банкнаас зээл олгогдсон иргэн Д.Эрдэнэжаргал, Д.Түвшинбаатар, Д.Давхарбаяр, Г.Ганболд, Г.Төртогтох, Б.Батзориг, Г.Гансүвд, Б.Чинтуяа болон “Зомсбэ” ХХК, “Зэлмэбаатар” ХХК, “Эн Би Жи” ХХК, “Гео-Арвижих” ХХК, “Хаан хатдын зоог” ХХК-ууд 504,1 сая төгрөгийн зээлийг бүрэн төлж дуусгасан байна.

Харин тус банкнаас 1538,2 сая төгрөгийн зээл олгогдсон “Бөхлөг” ХХК, “Цэенхээ” ХХК, “Мянган мөөжгий” ХХК, “Өлзийт энсада” ХХК, “Их баян бүрд” ХХК, “Оч манлай” ХХК, “Алтан Од гэрэл” ХХК болон иргэн Х.Болдбаатар, Ө.Осгондаваа, Б.Баярсайхан, Д.Ариунбат, Д.Халзан, Б.Билэгням, С.Оюунтуяа, Д.Бадрал нарын зээлдэгчид зээлийг графикайн дагуу 696,1 сая төгрөгийг төлж, 842,1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хөнгөлөлттэй зээл авсан иргэн, аж ахуйн нэгжүүдээс 4 иргэн, аж ахуйн нэгж 181-1092 хоногийн хугацаа хэтэрсэн 97,1 сая төгрөгийн зээлийн өртэй байна.

Хөнгөлөлттэй зээлээс иргэн Б.Борхүү 26,6 сая төгрөгийг 549 хоног, “Онон-Өлзий” ХХК 65,5 сая төгрөгийг 1092 хоног, “Хэнтий гутал” ХХК 3,8 сая төгрөгийг 202 хоног, иргэн Д.Жаргал 1,1 сая төгрөгийг 181 хоног тус зээлийн төлөлт хугацаа хэтэрсэн байна.

Аудитад салбарын яамнаас газар тариалангийн 4 аж ахуйн нэгж, сүү боловсруулах 1 аж ахуйн нэгжид шууд олгосон нийт 1855,0 сая төгрөгийн 5 төслийн зээлийн эргэн төлөлтийн мэдээлэл хамрагдаагүй болно.

3. Төсөл хэрэгжиж төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх,

Аймгийн хэмжээнд Хөгжлийн банкнаас санхүүжилт авсан 37 төсөл арга хэмжээг аудитын хугацаанд судалгаанд хамруулан нэгтгэн дүгнэхэд 17 төсөл хэвийн үйл ажиллагаагаа явуулж 45 байнгын ажлын байр, 6 төсөл улирлын чанартай хэрэгжиж 25 түр ажлын байрыг бий болгосон бол үлдсэн 14 төсөл зорилтод үр дүнд хүрч ажлын байр бий болгосон нь тодорхойгүй байна.

Аудитын хугацаанд Хэрлэн суманд олгогдсон төслүүдийн хэрэгжилттэй газар дээр танилцах, бусад төслүүдийн хэрэгжүүлэгчтэй холбогдоход 467,1 сая төгрөгийн 13 төслийн хэрэгжүүлэгч болох "Зэлмэбаатар" ХХК, "Цэенхээ" ХХК, "Хаан хатдын зоог" ХХК, "Их баян бүрд" ХХК, "Эн Би Жи" ХХК, "Зомсбэ" ХХК, "Алтан Одгэрэл" ХХК иргэн Д.Түвшинбаатар, Ө.Осгондаваа, Х.Болдбаатар, Д.Давхарбаяр, Г.Ганболд, Г.Төртогтох нар зээлийг зориулалтын дагуу ашиглаж 45 ажлын байрыг шинээр бий болгон тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.

Улмаар "Мянган мөөжгий" ХХК, "Өлзийт энсада" ХХК, "Батширээт сүү" ХХК, "Оч манлай" ХХК болон иргэн Д.Ариунбат, С.Оюунтуяа нарын 6 зээлдэгч 1215,0 сая төгрөгийн 6 төсөл хэрэгжүүлж улирлын чанартай үйлдвэрлэл явуулан 25 хүнийг түр ажлын байраар хангаж байгаа бол "Гео-Арвижих" ХХК болон иргэн Д.Эрдэнэжаргал, Д.Жаргал, Д.Бадрал нарын хэрэгжүүлсэн 327,0 сая төгрөгийн 4 төсөл нь шинээр ажлын байр бий болгоогүй хөрөнгө оруулалтын чанартайгаар зээлийг зарцуулжээ.

Харин 163,2 сая төгрөгийн 7 төсөл хэрэгжүүлэгч "Онон-Өлзий" ХХК болон иргэн Б.Борхүү, Б.Баярсайхан, Б.Билэгням, Б.Батзориг, Г.Гансүвд, Б.Чинтуяа нар төслийн хэрэгжилтийг зогсоосон нь Хөгжлийн банкнаас олгосон зээлийн хэрэгжилт үр дүнгүй болоход нөлөөлжээ.

Мөн "Бөхлөг" ХХК, "Хэнтий гутал" ХХК болон иргэн Д.Халзан нар нь төслийн хөрөнгө оруулалт 78,0 сая төгрөгийг зориулалтын дагуу ашигласан эсэх нь тодорхойгүй байна.

Жич: Хавсралт 2 хуудас

Танилцуулга бичсэн: Ахлах аудитор

Хянасан: Аудитын менежер



Д.Эрдэнэбилэг

Д.Оюунтуяа